

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 01 дүгээр сарын 11

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.				
1	Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтийг бүрэн хангаж 2023 онд 28 удаагийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 231 үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Үүрэг даалгаврын хэрэгжилтийн дундаж 76.83%-тай үнэлэгдсэн.			70
Үүрэг даалгавар ХОЁР: Хотын нийтийн аж ахуйн чиг үүргийг дүүргүүдэд шилжүүлсэнтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн арчлалт үйлчилгээ, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалтыг дүүргүүд бүрэн хариуцаж, Захирагчийн ажлын албанаас хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.				
2	Хот нийтийн аж ахуйн зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-аас шилжин ирж байгаа зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний нийт 46 ажилтан албан хаагч, дүүргийн нутаг дэвсгэрийн 5 байршил буюу нийт 5,3км урт авто зам, нийтийн бие засах газар 4, Энержи комплекс ХХК-ийн хариуцан ажилладаг 1925 гэрэлтүүлэг, 6 байршилд 4,3км ногоон байгууламжийн ажлыг 2023 оны 01 дүгээр сард дүүрэгт хүлээлгэн өгсөн. Тохижилт үйлчилгээг Тохижилт үйлчилгээний ХХК-д, гэрэлтүүлгийг Соён дримм ХХК-д тус тус хариуцуулан хяналт тавьж ажиллаж байна.			100
Үүрэг даалгавар ГУРАВ: Нийслэлээс мал гаргах ажлыг шуурхай зохион байгуулах.				
3	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/07 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны А/27 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 04-06-ны өдрүүдийн хооронд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, нийслэлийн Мал эмнэлгийн газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Зуслангийн бүсийн Цагдаагийн тасаг, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах			100

	нийгэмлэгийн дарга, 1-24 дүгээр хороодын ажлын албатай хамтран хотын төв, суурин газруудаас 550 гаруй тооны адуу малыг хориглосон бүсээс гаргаж ажиллалаа.			
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцсан орон сууцны хорооллын дундах авто зам, явган хүний зам, гудамж талбайн цас, мөс, хог хаягдлын цэвэрлэгээ үйлчилгээнд нь дүүргүүд тогтмол хяналт тавьж ажиллах.				
4	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсээс 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 15, 24 дүгээр хороодын сууц өмчлөгчдийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг чиглэл өгч, авто зам болон явган хүний замын цас, мөс, хог цэвэрлэгээг хийлгэж, хэсгийн ахлагчид бүрэн хяналт тавьж, шаардлагатай газруудад албан бичгээр үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын ажилтан албан хаагчид хариуцсан хороодын нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, аж ахуйн нэгж, байгууллагуудын хариуцах орчны 50м хүртэлх талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд хуваарийн дагуу тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 01 дүгээр сарын 03-05, 10-ны өдрүүдэд орсон цаснаар нийт 8 ажилтан албан хаагч нартай хамтран хяналт тавин ажилласан.			100
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цас, мөсийг цэвэрлэж, хэрэгжилтэд нь дүүргүүд тогтмол хяналт тавьж ажиллах.				
5	Дүүргийн нутаг дэвсгэр дэх зам талбайн цас мөсний цэвэрлэгээнд 2023 оны 01 дүгээр сард давхардсан тоогоор нийт 1626 иргэн, 75 төрийн байгууллагын 140 ажилтан албан хаагч, 1257 аж ахуйн нэгж, байгууллагын 1535 ажилтан, 101 сууц өмчлөгчдийн холбоодын 175 ажилтан, Ерөнхий боловсролын 48 сургууль, цэцэрлэгийн 98 ажилтан албан хаагчид хамтрагдан нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн нийт 86,365м ² талбайн цас мөсийг цэвэрлэн ажиллалаа. Цэвэрлэгээний ажлын явцад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс хяналт тавин ажиллаж байна.			100
Үүрэг даалгавар ЗУРГАА: Хот нийтийн аж ахуйн тоног, төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх				
6	Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 18 дугаар тогтоолын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 54 төсөл арга хэмжээ батлагдсанаас нийт 8 төсөл арга хэмжээний тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааны 2,581,168,600 төгрөг байна. Цаашид 2024 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдөрт багтаан төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn болон www.chingeltei.gov.mn цахим системээр дамжуулан ил тод нээлттэй зарлаж, урилга, үр дүнг нийтлэн шуурхай эрчимжүүлж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.			70
Үүрэг даалгавар ДОЛОО: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд санал боловсруулах ажлын хэсэг байгуулах.				

7	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ний өдрийн А/03 дугаар тушаалаар тус хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд санал боловсруулах ажлын хэсэг байгуулсан.			100
Үүрэг даалгавар НАЙМ: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 100 хоногийн ажлын тайланг гаргаж танилцуулах.				
8	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн эхний 100 хоногийн хугацаанд нийслэл хотод зохион байгуулж хэрэгжүүлсэн томоохон ажлуудын хүрээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын авч хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 3/60 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.			100
Үүрэг даалгавар ЕС: “Урт цагаан”-ыг буулгах ажлыг эрчимжүүлж, орчны аюулгүй байдлыг хангаж, цэвэрлэгээ, тохижилтын ажлыг сайтар зохион байгуулах.				
9	Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/02 дугаар тушаалын дагуу Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Урт цагаан”-ны барилгыг нураах, түрээслэгчдийн эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 04, 07-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Урт цагааны барилгыг буулгах ажлыг эрчимжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангахын тулд зүүн талд байрлах 3 ТҮЦ, 1 хуушуурын чиргүүлтэй зөөврийн машиныг 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 22:00 цаг хүртэл дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран нүүлгэн шилжүүлэн ажиллалаа.			70
Үүрэг даалгавар АРАВ: 2024 онд хийх тохижилтын ажлын төлөвлөгөөний зураг, төслийн ажлыг яаралтай танилцуулах.				
10	Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх 6 дугаар хорооны 2 байршил, 16 дугаар хорооны 1 байршилд зураг төсвийн ажил хийгдэж худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 1 тэрбум 800,0 сая төгрөгийн 29 төсөл арга хэмжээний ажлуудын зураг төсөв хийхээр зураг төсвийн компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.			70
Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 7 хоног тутамд хийсэн ажлуудаа хэвлэл мэдээлэл, олон нийтэд сурталчлах ажлуудыг зохион байгуулах.				
11	Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газрын харьяа хэлтэс албадын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр тутмын мэдээ зөвлөмжийг Чингэлтэй дүүрэг /Chingeltei District фэйсбүүк пэйж хуудас, Chingeltei.gov.mn вэб сайтад цаг алдалгүй хүргэн ажиллаж байна. “Чингэлтэй дүүрэг, Chingeltei District фэйсбүүк, пэйж цахим хуудсанд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд дүүргийн харьяа хэлтэс, тасаг, албадын 77 мэдээ мэдээллийг байршуулсан байна.			100
Үүрэг даалгавар АРВАН ХОЁР: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд “Болзолт уралдаан” зарлах захирамжийн төслийг боловсруулж танилцуулах.				

12	<p>Дүүргийн 1-24 дүгээр хороодын албан хаагчдыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх зорилгоор “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдаан, Улаанбаатар Захирагчийн Ажлын албанаас хотын тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтэц, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдэд ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Манай хороо-Миний гудамж” аяны уралдааны талаар мэдээллийг дүүргийн цахим хуудаснуудад тухай бүр мэдээлж ажиллалаа. Зургаа дахь жилдээ зохион байгуулагдсан шилдгүүдийг шалгаруулсан үйл ажиллагааны мэдээллийг бэлтгэн ажиллалаа.</p> <p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу “Цасаа цэвэрлэе” аяны талаар мэдээллийг хүргэж ажиллав. Мөн цэвэрлэгээний явц болон үр дүнгийн талаар 24 хороодын мэдээллийг дүүргийн цахим хуудсаар мэдээллээ.</p>			100
Үүрэг даалгавар АРВАН ГУРАВ: Нийслэлийн өмчийг шинээр бүртгэх, өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлууд эрчимжүүлж ажиллах.				
13	<p>Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон 3,872,825,230.00 төгрөгийн хөрөнгө, дүүргийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон 6,088,075,773.00 төгрөгийн хөрөнгө буюу нийт 9,960,901,003.00 төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг үндэслэн тухайн байгууллагын даргын тушаалаар бүртгэж, эзэнжүүлэн, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.</p>			100
Үүрэг даалгавар АРВАН ДӨРӨВ: Халиа дошинг арилгах төлөвлөгөөг гаргаж, шуурхай арга хэмжээ авч ажиллах.				
14	<p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс 2024 оны халиа дошинг арилгах төлөвлөгөөг гаргасан. Дүүргийн 7, 8, 17, 18, 19, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2023 оны 01, 02 дугаар сард үүссэн шар усны үер, булгийн болон хөрсний ус, халиа дошингоос урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдлыг шуурхай арилгах ажлыг дүүргийн “Тохижилт үйлчилгээний” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж нийт 6 хорооны нутаг дэвсгэрийн давхардсан тоогоор 16 байршилд шуудуу татах, хайрга, дайрга асгах, нийтийн эзэмшлийн зам талбайн мөс цэвэрлүүлэх ажилд 36,175,650 төгрөгийг зарцуулан ажилласан. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд дүүргийн Засаг даргын Тамгын газраас давхардсан тоогоор 11 албан хаагч, Онцгой байдлын хэлтсээс 26 алба хаагч, 3 тээврийн хэрэгсэл, Тохижилт үйлчилгээний ХХК-аас 32 албан хаагч, 4 тээврийн хэрэгсэл, хороодын ажлын албанаас 12 албан хаагч нийт 81 албан хаагч, 7 тээврийн хэрэгсэлтэйгээр ажилласан.</p> <p>Дүүргийн 5 хорооны 8 байршлын айл өрхийн хашаа, нийтийн эзэмшлийн зам талбайд мөсөн халиа үүссэн нөхцөл байдал үүссэн. Хороодын айл өрхийн өртөх эрсдэл- 8 дугаар хороонд 18 өрх, 17 дугаар хороонд 11 өрх, 20 дугаар хороонд 25 өрх, 23 дугаар хороонд</p>			100

<p>15 өрх, 24 дүгээр хороонд 7 өрх нийт 76 өрх, нийтийн 1,5 км зам талбай мөсөн халианд автсан нөхцөл байдалтай байсныг газар дээр нь шуурхай арга хэмжээ авч том оврын машинаар 300 м газар, 200 м³ хайрга дайрга асгаж, 285 тн хагалсан мөсийг нийт 19 удаагийн рейсээр зөөвөрлөн 565 м далан босгож 457 м шуудуу татаж ажилласан.</p>			
<p>Үнэлгээний дундаж</p>			<p>91.43</p>



